

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

|   |                                   |                     |                    |
|---|-----------------------------------|---------------------|--------------------|
| Ярилцлага өгөгчийн нэр                              | Жамаагийн Бямбаа                  | Дугаар              | L237               |
| Оршин суугаа аймаг                                  | Өмнөговь                          | Оршин суугаа сум    | Булган сум         |
| Төрсөн газар  | Булган сум                        | Төрсөн он           |                    |
| Ажил мэргэжил                                       | өндөр настан                      |                     |                    |
| Лам байсан эсэх,<br>Шавилан сууж байсан сүм<br>хийд | Бумбатын хийд,<br>Зоорингийн хийд | Сүм хийдийн дугаар  | ӨГБУ 005, ӨГБД 016 |
| Одоогийн сүм хийд                                   |                                   | Сүм хийдийн дугаар  |                    |
| Ярилцлага авсан он сар<br>өдөр                      | 2007 оны 6-р сарын 8              | Ярилцлага авсан хүн | Ц.Гантулга         |



Өмнөговь аймгийн Бумбатын хийд, Зоорингийн хийд

Гантулга: За судалгааны багийнхан Өмнөговь аймгийн Булган суманд ирээд Жамаагийн Бямбаа гэдэг хүнтэй энэ Бумбатын хийдийн тухай ярилцах гэж байна. За бямбаа гуай та өөрийгөө товч танилцуулаад, Бумбатын хийдийн тухай юу мэдэх вэ, товч танилцуулахгүй юу?

Бямбаа: За би бол яахав дээ, энэ хуучин Баяндалай сумын хүн. Энэ Бумбатаар бол хар нялхаасаа өссөн хүн байгаа юм. Хуучин одоо Балдан Засгийн хошуу гэж байсан, Баяндалай сумын харъяаны хүн. За одоо энэ Баяндалай сумын, Баяндалай сум гэж байхад зургаа долоо гэж хоёр баг байсан байгаа юм. За долдугаар багийн нутгийн хүн байсан юм гэнэ лээ. Тэгээд энэ Булган сум байгуулагдаад хоёр баг нь Булганд орсон. Тэгээд Булган сумын харъяат болсон хүн. Тэгээд одоо энэ Бумбатын хийдийн талаар сайн мэдээд байх юм надад алга юм. Миний бага байхад одоо тавин тав, зургаан оны үед л болов уу гэж бодоод байгаа юм. Энэ Бумбат дээр багийн

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

төв байсан юм. Бодвол одоо тэр Болоо гямангийн төв гэдэг нь болов уу гэж санаад байгаа юм. Манайх л лав энэ багийн айл байсан юм. Тэгээд энэ нэг дөрвөлжин их сайхан дуган байсан юм. Хуучин том дуган гэж ярьдаг байсан. Одоо голдоо дөрвөн том баганатай байсан. Тэгээд хөх дүнзээр барьсан тийм байшин байсан байгаа юм даа. Энэ байшинг сүүлд нь энэ Дэн баригаг гэдэг байгуулаад, тэр дуганыг аваачаад, нурааж аваачаад тэнд багийн төв барьсан байгаа юм. Одоо миний мэддэг юм л энэ хэдэн нүх л байна даа

Гантулга: Энэ одоо эргэн тойрон ер нь тэр дуганаас өөр юм байсан уу? Хэмжээний хувьд?

Бямбаа: Ер нь хэмжээ гэвэл ерөнхийдөө бас нэлээн олон хүмүүс амьдардаг газар байсан болов уу. Лам нар юутай хурлын юу бол гайгүй олон юутай басйн болов уу гэж бодож байна.

Гантулга: Нутаг дэвсгэртээ бол?

Бямбаа: За нутаг дэвсгэр тэр байгуулагдаж байсан газрыг нь харахад бол хааш хаашаага бол хоёр зуун метр газарт бол багтах байх. Тэр л орчимд байх, газар нутаг нь бол.

Гантулга: Тэр тууринууд нь бол атаршаад дэрс ургаад?

Бямбаа: Аа тууринууд нь бол дэрс ургаад зарим нь мэдэгдэхээргүй болчихсон. Тэгээд ерөнхийдөө сайн дотор нь яваад ажиглаад үзэх юм бол арав хориод шахуу байшин байсан болов уу. Тэгээд нэг хорь гучаад айл байсан гэмээр. Тийм л байсан.

Гантулга: Аан. Тэр суурь нь гэхэд гэр байшингийн суурь, гэрийн нь одоо дугуй суурь ч юмуу мэдэгдэх үү?

Бямбаа: Одоо гэрийн довжоонууд бол бий. Дандаа чулуун довжоо засаад гэр барьчихсан.

Гантулга: Тэгээд дугуйруулаад барьчихсан.

Бямбаа: Тийм, тэгээд хаанаас ачиж байсан юм, тэмээгээр ачиж байсан юм уу мэдэхгүй. Одоо нэг том том хавтгай чулуунууд байдаг юм даа, жижигхэн ширээний тавцны дайны. Би бас нэг ноднин том том чулуу гарч ирээд байхаар нь нэг хороо барих санаатай хэдийг буулгаад аваад буулгачихсан л байгаа л даа

Гантулга: Аа мөн. Одоо энэ нэр усных нь талаар бол одоо тийм хурал гэж одоо өөрөөр дуулаагүй юу?

Бямбаа: Одоо энэ Бумбатын хурал гэж яриад байдаг юм, улсууд. Одоо ч тэгээд дарагдсан нурсан болгоныг л хурал гэж яриад байгаа юм л даа. Одоо би энэ Өмнөговийн товч түүх гэдэг номыг энэ Юндэнбазар гэж хүн бичсэн байсан юм. Манай энэ аймгийн дарга байсан юм л даа. Тэгээд Юндэнбазрын бичсэн Өмнөговийн товч түүхийг уншиж байхад Бухалтын хийд гээд биччихсэн байсан юм. Бухалтын хурал гэж. Энийг би тэгээд энэ Бумбатыг л Бухалт гээд биччихэж дээ гэж бодож байсан.

Гантулга: Андуурч?

Бямбаа: Тийм андуурч бичсэн юм болов уу даа гэж бодож байсан. Зарим юман дээр нэг мэдэх нэрийг андуураад биччихсэн байдаг шүү дээ. Ер нь тийм нэртэй ч байсан юм уу, хэн мэдэхэв

Гантулга: Энэ одоо ойролцоо энэ хийдтэй ойролцоо сүм хийд байна уу, ер нь?

Бямбаа: Ерөөсөө энэ хавьд бол одоо нээх юм байхгүй байсан. Харин энэ өвөр лүүгээ бол бий л дээ.

Гантулга: Энэ Баяндалай сумын хуучин нутагт байсан юм байна. Тэгэхээр энэ Баяндалай сумынхаа хурал номтой холбоотой л байх даа, бодвол?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Бямбаа: Аа байсан байх. Энэ Баяндалай сумын одоо Зоорингийн хийд гэж ярьдаг юм.Тэрэн дээр Шавран гэж лам нь хамба лам нь байсан гэж байгаа.

Гантулга: Шавран ?

Бямбаа: Тийм, Шавран гэж. Аа тэр Шавран гэдэг лам бол миний эцгийн төрсөн ах нь байгаа юм

Гантулга: Өө тийм үү, за?

Бямбаа: Одоо тэгээд энэ үзүүрт нэг овоо тахидаг юм.Одоо тэгээд маргааш тахих гээд л , би бас явах гээд л ...

Гантулга: Тэр хүний талаар, тэр Шавран ламын талаар та хэлэх юм байна уу?

Бямбаа: Одоо тэр Шавран гэдэг ламыг цагдаад л явсан юм гэнэ лээ.Тэгээд бодвол хороогдсон л байх л даа.

Гантулга: Зүгээр эрдэм номынх нь чадлын талаар?

Бямбаа: Аа эрдэм номын чадал нь бол бороо зороог оруулдаг.Ерөнхийдөө бол бороог бол чөлөөгүй оруулдаг .Зөвхөн энэ овоогоо тахихад ч оруулдаг байсан.Зүгээр жирийн бараа бологчтойгоо явж байгаад хөдөө очоод одоо унтаад хэвтээд байгаа юм шиг л байдаг.Тэгж байгаад л босоод явахаар бороо ордог, өөрөө хуурай.Тийм л хүн байсан юм гэнэ лээ.

Гантулга: Өшөөгөөр дуулсан юм одоо?

Бямбаа: Байхгүй дээ.Ерөнхийдөө бол өнөө шамбарам гэдэг өвчнийг анагаадаг, дээлийн товчоор нь утдаг.Тэгээд одоо бол манай энэ Балдан засгийн хошууныхан бол Шавран ламыг одоо хүртэл шүтэж явдаг.

Гантулга: Яаж эдгээдэг байсан юм бол?

Бямбаа: Өө дээлийн товчоор утдаг.Өөрөө ч их зүрхгүй лам байсан гэдэг юм.Тэгээд ам хамраар нь шаамар тусаад ирсэн хүнийг элгэлж байгаад гаргачихдаг.Тэгээд нөгөө хүн нь уурлаад багш та одоо ингэлээ, намайг өвдөж үхэх гээд байхад инээгээд элгэлээд гэхэд тэгээд маргааш нь зүгээр болчихсон байдаг.Тийм л хүн байсан.

Гантулга: Дээлийн товч гэхээрээ энэ зангидсан...?

Бямбаа:Өө яг дээлийн хадсан товч

Гантулга: Ямар ч л дээлийн хамаагүй юу?

Гантулга: Үгүй ээ, энэ зөвхөн өөрийнх нь лам хүний өмсдөг дээлний

Гантулга: Аан өөрийнх нь дээлний?

Бямбаа: Товчийг нь ханз бариад л утчихад зүгээр болчихдог байсан.Тийм л түүх ярьдаг байсан ш дээ.

Гантулга: Энэ овоо чинь одоо эндээс хаахна байна, ямар нэртэй овоо байсан бэ?

Бямбаа: Энэ Ламын овоо гэж.Энэ дээд уул, одоо харагдахгүй байна.Энэ уул шувтраад бий, үзүүрт нь

Гантулга: Дунд хайрхны үзүүр шувтраад уу?

Бямбаа: Энэ Баруун сайхны үзүүр шувтраад ш дээ. Баруун сайхны үзүүр шувтраад. Тэгээд энэ хоёр гурван Булган, Баяндалай сум тахидаг.Одоо энэ нэг мухар луу тахидаг байсан юм.Анх ардчилал гараад ерэн оноос хойш тахисан юм.За тэгээд ерөнхийдөө тэр лам нь шар морь халиун морь хоёрыг сэтэрэлдэг байсан юм.Үр удам нь юм гэж шар морь сэтэрэлдэг байсан юм.

Гантулга: Тийм байна, тэр хадагтай шар морь.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Бямбаа:Зудын жил нэг шар морь сэтэрэлдэг , өнөөх маань зудаас өмнө ерэн онд бас нэг шар морь сэтэрлэж байсан.Тэгээд манай нэг хүргэн хүү, өнөө мүү Нацагдорж гэж байдаг юм .Тэр нь нэг халиун морь...тэгээд хоёулаа яахав , ёсыг бодож нэг морь тавья гээд хүргэн хүү халиун морь...Тэгээд зудаар түрүүлж сэтэрлэсэн хоёр морь зудаар үхээд өтлөөд.Тэгээд би саяхан нэг шарга морь сэтэрлээд, хүргэн ч халиун морь сэтэрлэхсэн юм.Тэгээд унааныхаа морь эд нарыг бариад маргааш хөдлөх санаатай.

Гантулга:Аа мөн.Та энэ Баяндалай сумынхаа хийд , одоо сүм хийдийн талаар дуулсан мэдсэнээ?

Бямбаа: За тэр наана чинь одоо дөхөхөөрөө зэрэг Баяндалай сумын Байшинтын хийд гэж байдаг юм.За тэр Баяндалай өмнө голдуу.Тэр урдүүр, Хонгорын овоо гэдгийн өвөрт.За тэр Шавран лам чинь , энэ Зоорингийн хийд гээд өөрийн нь байгуулсан хийд байсан юм.

Гантулга: Хэр том хийд байсан юм?

Бямбаа: Өө бас хөөрхөн л юм байсан байх даа.Одоо ч тэгээд нураагаад юу ч үгүй болсон юм.Зайлуул өвөлжөө барьчихсан байсан.Байшинтын хийд ч бас байхгүй болсон.Гучин усны хийд гэж тэр зүүн сайхны үзүүр дээр байдаг юм

Гантулга: Бас Баяндалайгийнх?

Бямбаа: Тийм, одоо бараг Хүрэмнийх гэхээр шахуу болчихсон юм даа.Хүрэмний нутаг болчихсон юм. Тэр хувилгаан лам гэдэг тахиж шүтэж байсан юм гэнэ лээ. Одоо хамба нь байсан юм.За тэр Шавран лам чинь одоо Зоорингийнхоо хийд дээр байдаг. Тэгээд бас Байшинтын хийдийг голлож байсан хүн юм билээ. Хоёр хийдэд амьдарч, хооронд нь явж байдаг.Гол их наадам одоогоор улсын наадам майдар цож эргэнэ гэж тэр Байшинтынхаа хийд дээр очиж хийдэг байсан

Гантулга: Аа мөн, майдар юу эргэнэ гэнэ ээ?

Бямбаа: Майдар цож эргэнэ гэж.Одоогоор бол нэг ёсондоо өвлийн цагт хийдэг байж, одоо манайхны ёолк тэмдэглэхтэй адилхан./инээв/ Тиймэрхүү л байан шиг байгшаа юм. Би ч юу ч мэдэхгүй үед л өссөн хүн юм.Яг юу энэ лам хийдийг чинь татаад явчихсан, юу ч мэдэхгүй үе дээр өссөн одоо тэгээд жараад жил болж байна даа.

Гантулга: Аав тань бол одоо байх байсан бол хэдтэй хүн байх байсан бэ?

Бямбаа: Манай аав одоо байх байсан бол ерэн хэдтэй хүн байх байсан

Гантулга: Тэгэхээр лам хувраг байсан хүн үү?

Бямбаа: Манай эцэг бол лам байгаагүй. Ах нь лам болгоогүй адуугаа маллуулж байсан гэдэг.

Гантулга: Аа мөн?

Бямбаа: Хувийн адуу нь мянга хүрч байсан гэдэг.

Гантулга: Шавран лам чинь бол эцгийн чинь ах юм байна ш дээ?

Бямбаа: Төрсөн ах нь ...Эхээс нэлээн олуулаа байсан .Хоёрхон нь хүү.Тэгээд ...

Гантулга: Нэг нь лам?

Бямбаа: Нэг нь лам , нэг нь бүр тодорсон лам гэж байгаа юм. Тэр Шавран лам гэдэг бол долоон дүрээ залгуулсан лам гэж.Долоо дүрээ залгуулсан лам гэж

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Долоо дахь нь байсан , хамгийн сүүлийнх нь байсан?

Бямбаа: Тийм. За нэг нь бол сүрхий ингээд нэг их ном мэддэг лам. Шавраар хүн хийдэг, ингээд энэ чиний төрх нь гээд ном бясалгаад байдаг юм байна л даа.Тэгээд одоо танай төрх ч юмуу.Тэгээд хоёрдугаар төрх нь тодроод ирэхгүй юу.Тэгээд одоо тэрнийг ингээд нас өөд болохын алдад хэнийд төрөх нь вэ гээд уншаад байхад эднийд төрөх жишээтэй.Дарагийнх нь манайд төрөх жишээтэй .Тэгээд явсаар байгаад шавраар хийсэн хүн нь , доло дахь төрөл нь тэгээд Шавран лам тодорчоод тэгж тодруулдаг байсан юм. Тэгж тодорчихоод тэгээд тэр Шавран гэдэг нэрийг бол тэрнээс...

Гантулга: Аан тэр шаварнаас?

Бямбаа: Тийм, тэр шаварнаас анх үүдэлтэй гэж. Шавран гэж тийм домогтой гэж.Уг нь бол Лувсансодномбаанжил гэж хүн байсан юм. Содном баанжил гэдэг нэргтэй хүн байсан юм .

Гантулга: Содномбаанжил аа?

Бямбаа: Баанжил. Тийм.

Гантулга: Шавран гэдгийн нэр нь юм байна тиймээ?

Бямбаа: Тийм. Шавран гэдгийн нэр нь Содномбаанжил.

Гантулга: Содном баанжил юм уу, ваанжил юм уу?

Бямбаа: Ваанжил.

Гантулга: Энэ хамгийн сүүлийнх нь дүрийнх нь нэр юм байна ш дээ?

Бямбаа: Тийм, дүрийнх нь нэр.Шавран гэдэг чинь тэр...Шавран багштан гэж дээхнэ үед олон хүн мөргөдөг байсан даа

Гантулга: Тэр хүмүүс Шавран гэгээн энэ тэр гэх үү?

Бямбаа: Аа тийм. Шавран лам гээд л .Багштан л гэж голцуухан ярьдаг.Манай эцэг Лувсан гэж хүн байсан юм. Энэ хүн Лувсансодномаванжил гэдэг хүн байсан .За нэг хэлмэгдлийн үеийн юмыг би нэг саваагүйтэж нэг нууцаар ганцаараа үзээд байхаар нь очиж үзэж байсан л даа.Тэгээд яг Содномваанжилаараа бичүүлчихсэн юм билээ.Тэгээд манай эцгийг чинь нэг ёсондоо эсэргүүний үлдэгдэл гээд ц”эрэг сурагт ч явуулдаггүй, ном эрдэм ч сурсан юм байдаггүй, тэр үед чинь сургууль соёл ч байгаагүй.За яахав ёстой нэг том хүний зэрэгт нэг шинэ үсэг мэддэг байсан юм уу, үгүй юмуу.Тийм л хүн байсан даа , манай эцэг.Тэгээд насаараа адуу малласаар байгаад нас барсан даа.Тэгж байгаад сүүлд нь надад үлдээгээд...

Гантулга: Тэр одоо шавар бурхныг бүтээчихээд уншаад байсан ламынх нь талаар?

Бямбаа: Тэрнийг ёстой мэдэхгүй юм , би.Тэгсэн түүхтэй л юм билээ гэж ярьдаг юм.Тэгээд одоо нэг мөр гаргах гээд мөрийн сан гээд юм байдаг юм байа л даа, одоо гарч ирсэн юм байна л даа.Тэрэн дээр одоо яасан байгаа юм , тэр мөрийн санг Төвд, Хятадын юу нь ч байдаг юм ,тэр Шавран Бээр монгол хэл дээр орчуулав гэсэн юм байгаа юм.

Гантулга: Тэр мөрийн сан дээр нь үү?

Бямбаа: Тийм.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Одоо танайд бий юү?

Бямбаа: Бий.

Гантулга: Ном судраас нь өөр юм байна үү?

Бямбаа: Байхгүй .

Гантулга: Тэр номыг чинь үзэж болох үү?

Бямбаа: Үгүй одоо орчин үеийн кириллээр яачихсан байгаа юм л даа.

Гантулга: Хамаагүй ээ.

Бямбаа: Бир энэ дэлгүүрээс авсан юм.Тэгээд үзэж байх нь ээ тэр Шавран орчуулав гэсэн юм байгаа юм.

Гантулга: Аа тэгвэл тэрийг чинь үзье.

Бямбаа: За би аваад ирэх үү.

Гантулга: Энэ ламынхаа зурагны талаар тодруулж та хэлж өгнө үү?

Бямбаа: За энэ ламын зургийг бол манай эцгийг амьд сэрүүн байхад бол багийн дарга Сундуй гэдэг хүн бол жаран гурван онд өгсөн юм

Гантулга: Тэгээд танд өгсөн юм үү?

Бямбаа: Тэгсэн юм , манай эцэг...

Гантулга: Энэ зурган дээр хэн хэн байна одоо?

Бямбаа: Энэ зурган дээр одоо энэ Шавран лам бол өөрөө байгаа юм

Гантулга:Баруун гар талдаа юү?

Бямбаа: Одоо баруун гар талдаа.Энэ зүүн гар талд байгаа нь энэ хувилгаан лам гэж.тэр зүүн сайхны баруун үзүүрийн Хошуу хийдийн хамба байсан.хувилгаан лам л гэдэг юм билээ.За энэ нэг сахалтай имй хүн байдаг юм.Ийм л юм байдаг юм даа. Тэгээд би энүүнийг надад өгсөн болохлээр нь бурхныхаа юүнд хийгээд хадгалж явдаг юм.

Гантулга: Энэ Шавран ахын чинь аав маавд чинь үлдээсэн ном судар гэж бол...?

Бямбаа: За ер нь яг ном судар бол надад байхгүй. Ерөнхийдөө энэ Шавран лам бол маш уран хүн байсан.

Юмыг нь хураагаад тэгээд манай эцгийг чинь бараг эсэргүүний үлдэгдэл гээд...Одоо маш уран хүн байсан.Тэгээд хийсэн юм нь энэ. Шатар матрыг чинь бол янзын гоё сийлдэг. Янзын зураач , уран хүн байсан.

Тэгээд манай эцэг чинь бүх юмаа хүнд өгөөд...

Гантулга: За энэ цацалныхаа талаар та ярихгүй юү?

Бямбаа: За энэ цацал бол Шавран лам өөрөө сийлж хийсэн юм гэнэ лээ.

Гантулга: Уран хүн байсан гэж?

Бямбаа: Тийм, уран хүн байсан гэж.За би энүүнийг нь тэр овоонд юм өргөдөг байсан болов уу гэж санадаг юм.

Гантулга: Аан за тахидаг овоондоо?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Бямбаа: Тийм. Тэгээд энэ овоон цацал бол энэ дээрээ уултай устай, модтой ингэд согоотой .Аа энэ ингээд жаргалын найман морь зурчихсан байдаг юм.Энэ хоёр морийг ингээд хараад байхад халиун цоохор морь байдаг юм.Шарга морь хоёр Оонын морь зогсож байгаа болов уу гэж...

Гантулга: Аа нөгөө?

Бямбаа: Тийм, тэр хоёр морь нь зогсож байгаа болов уу гэж ингэж боддог юм .Тэгээд биднүүс энийг гаргадаггүй байсан юм аа.

Гантулга: Энэ овоо чинь нөгөө тахилгат овооны л?

Бямбаа: Аа тийм дүрс маягийн л юм байх шиг болоод байгаа юм.Тэгээд нэг энэ усны долгио орж ирээд энэ...

Гантулга: Булаг?

Бямбаа: Тийм , булаг .Тэгээд нуурархууу , тэнд нь усны шувууд хөвж байгаа.Одоо цэцэг байгаа ш дээ.Энэ хонхон цэцэг маягтай ийм цацал байдаг юм.

Гантулга: Өөр одоо Шавран ламын гараараа хийсэн эд зүйл?

Бямбаа:Манай хүргэнийд нэг шатар байдаг юм. Одоо энд байхгүй ээ. Гэр нь аймгийн төв дээр байдаг юм.

Гантулга: Аан гэрийнх нь хаягийг авъя. За Намсрай Дүүрийд нь байгаа шатар, энэ цацал хоёр бол манай хүргэнийд байдаг юм.Энэ цацлыг бол би одоо овоонд авч явах гээд л ингээд хадгалж явдаг.

Гантулга: Энэ бол тани ааваас чинь уламжилж ирсэн үү?

Бямбаа: Үгүй ээ, энүүнийг би бол ааваас уламжилж аваагүй юм.Манай эцэг тэр нэг танил тал ламындаа өгчихсөн байсан юм.За тэр шатар энэ тэрээ.Тэр нутгийнхаа нэг танил ламындаа л өгчихсөн байсан юм.

Гантулга: Аа мөн мөн?

Бямбаа: Тэгээд ерөнхийдөө бол юмыг нь өөрт нь байлгадаггүй басан юм байгаа юм.Цэрэг сурагт ч явуулаагүй.Цэрэгт мордох гэж байсан чинь мөнгө төгрөг аваад ир гээд эсэргүүний үлдэгдэл гээд л үлдээж байсан. Тэгээд нэг иймэрхүү л юм ярьдаг юм .Тэгээд тэр лам нь зүүж байсан гээд хорь гаруй хадаг зүүлгээстэй.Тэгээд хамгийн сүүлд нь л энэ хадаг манай хүргэнд үлдэж байна даа

Гантулга: Өөр одоо энүүгээр янз бүрийн тийм?

Бямбаа: Аа нэг гүү уяхад цацлаа өргөнө.

Гантулга: Цацлаа өргөнө?

Бямбаа: Овоонд аваачиж бас өргөдөг байсан.Манайд нэг, том шатар байсан юм .Тэр хүний.Одооби бага байхад зөвхөн одоо тэмээ нь бол бараг энүүн дайны.Шүдэнзний хоёр хайрцаг шиг.Манай эндхийхэн чинь хаашаа юм, хүүхдийн тоглоомноос өгнө гэж авч явсаар байгаад байхгүй болчихсон.Тэгээд хоёр ноён байсан юм , тэгээд бид хоёр чинь долоо найман хүүхдтэй улс байгаа юм.Тэгээд хүүхдүүдээ өгөөд алга болсон.Одоо энэ хүргэнийд байга шатар бол юу юм байгаа юм.Найман хүү байна ш дээ, нэг талын найман хүү нь найман янзын мэх хийж байгаа барилдаж байгаа бөхтэй.

Гантулга: Аа тийм шатар?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Бямбаа: Нэг талын найман хүү нь болохоор дандаа хурдан морь унаад , найман хурдан морин дээр найман янзын суудлаар суучихсан.Тийм хүүтэй тийм шатар байдаг юм.

Гантулга: Аан тэгэд бусад шатруудынх нь тухай яривал одоо?

Бямбаа: Аа бусад шатруудынх нь хувьд бол яахав том нугастай. Тэгээд нэг талыг нь энэ ширээний тавцан шиг.Нэг талыг нь нээдэг нугастай.Тэгээд хаачихдаг ,тийм авдарных шиг гозойлгочихдог.Бид хоёр одоо шатар нүүхэд бол энэ дайны газраас нүүнэ.

Гантулга: Хөөх, их хол?

Бямбаа: Тийм , тийм шатар байсан юм.Тэгээд манайд байсан шатрын нэг талынх нь хүү бол дандаа туулай.Нэг талын нь хүү бол дандаа үнэг байсан юм.Тэгээд энэ Баяндалайд даага сургаж байсан Юүнгэрэг гэж хүнд, тэр ламын даага сургадаг хүн байсан юм.Тэрүүнд жаргалын найман морь , хоёр оросон буу, тэгээд өөрийн нь бөх байсан юм гэнэ лээ.Тэгээд би одоо тэр бөхийг нь сайн танина л даа.Гэндэнбал гэж өвгөн байсан.Хонгороо Гэндэнбал гэж.Сайн барилддаг хүн байсан юм.Тэрний зурсан зургийг би нэг үзэж байсан юм.Харийн одоо байхгүй болсон гэнэ.Тэр хаяад алга болгосон гэж эртээр ярьж байсан.

Гантулга: Тэр одоо Хонгороо Гэндэнбалынх нь үр хүүхэд гэж байхгүй юу?

Бямбаа: За даа , байхгүй шахуу бож байгаа даа. Яг үр хүүхэд нь бод байхгүй.Зүгээр ах дүү садан нь бол байгаа л даа. Тэд нарт ч мэдэх юм байхгүй л дээ

Гантулга: Танай хүргэнийд байгаа тэр шатар бүрэн шатар уу, ер нь?

Бямбаа: Бүрэн шатар.

Гантулга: Хүргэний чинь хэн гэдэг юм бэ?

Бямбаа: Намсрайдорж гэж одоо гадаа бий.

Гантулга: Ер нь энд малчин уу, одоо аймгийн төвд...?

Бямбаа: Малчин, хүүхдүүд хараад аймаг дээр гэр нь байдаг юм

Гантулга: Аа зөв зөв .

Бямбаа: Мал нь манайхнаар ингэсгээд байдаг юм . Тэгээд зун болохлээр хүүхэд хараад малтайгаа ингээд ...

Гантулга: За сайхан ярилцлага өгсөн таньд баярлалаа .Ингээд энэ сайхан зураг цацал...Амйаг дээр очихоороо бид нар тэр хүргэнээс чинь шатрынх нь талаар мэдээлэл аваад зургийг нь авъя

Бямбаа : Тэр ламын зураг манай хүргэнийд бий.Их том.Манай нэг ах байсан юм. Ноднин нас барчихсан юм.Хотод багш байсан юм.Тэгээд Баяндалайн хийд байгуулагдаад ерэн хэдэн онд билээ дээ...Тэгээд Баяндалайн хийд байгуулагдахад манай ах энэ зургий ,хөргийг жаазлаад нэгийг нь надад өгсөн юм. Нэгийг нь Баяндалайн хийдэд өгсөн юм.Хийдэд байдаг юм. Тэгээд хүргэний нэг ачийн минь ах миний нэг хайртай хүү байдаг юм.Өнөөхдөө би тэрүүнийг нь өгсөн юм.

Гантулга: Юугий нь ?



## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Бямбаа: Өнөөх зургийн нь.Том болгосон. Бүр ёстой татаж авахаар гоё зураг байсан, том болгосон. Энэ бол бүр яг эх зураг нь энэ байгаа юм.Тэгээд л энийг чинь улсууд хувилж аваад л байдаг юм. Дээр үед нөгөө танил тал айл саахалт байсан улсууд маань...

Гантулга: Эгч бол одоо бас Баяндалайн уугуул?

Гэргий: Уул нь Баяндалайн айлуд байсан юм гэнэ лээ.Манай энэ арын айлууд. Тэгээд л энэ Булган сүм байгуулагдахад Баяндалайн долдугаар баг гэдэг нь тасраад энэ Сайхныхаа...

Гантулга: Тийм гэнэ ээ. За баярлалаа